# Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

**Багахангай дүүргийн засаг даргын тамгын газар**

**2023 оны жилийн эцэс**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | | | |
| 1 | | 1.1. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | | - Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх. | - | - | “Шүгэл ажиллагааны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх аянд нэгдэн Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “Үгүй гэж хэлээд өөрчилье”, “Нэгдэх үү юуны төлөө”, ”Авлигатай тэмцэх таны оролцоо чухал”, “Авлигын эсрэг ҮГҮЙ гэж хэлээд өөрчилье”, “Бусдын боломжийг булаахгүй байх учраас ҮГҮЙ гэж хэлээд өөрчилье” видео контент, “Авлигын эсрэг нэгдье” 6 төрлийн постерийг дүүргийн bagakhangai.ub.gov.mn веб сайт, байгууллагын фейсбүүк хуудсуудаар сурталчлан ажиллаа.<br>"Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар шүгэл үлээхийг уриалан ажиллаж хороодтой хамтран “Авлига гэдэг нь зөвхөн бэлэн мөнгө солилцох үйлдэл биш”, “АТГ-аас 2022 онд мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн болон, 2022 онд улсын төсөвт учирсан нийт хохирол” шторк 150 ширхэг, “НЭГДЬЕ үгүй гэж хэлээд өөрчилье” стейкэр 200 ширхгийг дүүргийн төрийн болон төрийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бус 43 аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний 22 байгууллага, амралт чөлөөт цагийн 3 талбай, худаг-3, гэрлийн 60 шон, орон сууцны 20 байрны 61 орцны зарын самбарт байршуулан ажиллаа. | |
| 2 | | 1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах; | - | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | - | - | Хуулийн салбарын "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 2 удаа зохион байгуулав.<br>- 2023 оны 02 дугаар сарын 21-ний өдөр "Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил" –ийн нээлтийн арга хэмжээний үеэр "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгуулан дүүргийн хууль, хүчний болон аж ахуйн нэгжийн нийт 20 байгууллага оролцож, үйл ажиллагаагаа сурталчлан ажиллав.<br>- 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төр хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааг сайжруулах "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс, Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газар, Багахангай, Налайх дүүргийн прокурорын газар иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлан зөвлөгөө мэдээллийг 12 иргэдэд өгөн ажилласан байна.<br>"Нээлттэй хаалганы өдөрлөг"-өөр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн авлигын 4 төрлийн 20 ширхэг плакат, 6 төрлийн 80 ширхэг гарын авлага тарааж, 55 иргэнд хууль эрх зүйн болон хөрөнгө оруулалтын ажлын талаар мэдээлэл өгч, Авлигын эсрэг хуулийг сурталчлах 2 төрлийн гарын авлага бэлтгэн 30 гаруй иргэдэд хүргэн ажиллав.<br>Мөн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 5 "Ш" ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар сэтгэл ханамжийн судалгааг бэлтгэн 22 иргэдээс авсан болно.<br>Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2023 онд Нийслэлийн дүүргүүд агентлагуудын дунд зохион байгуулагдсан | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Мэдье, Нэгдье” аянд нийслэлийн хэмжээнд 3 байранд шалгарав. | | |
| 3 | | 1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах; | | -Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх. | | | Засаг даргын Тамын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн үйл ажиллагааны самбарт Авлигын үйл ажиллагааг мэдээлэх “АВЛИГЫН МЭДЭЭЛЭЛ” цонх байршуулан сар бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.<br>Мөн дүүргийн веб сайтын Ил тод үндсэн зэсэд Авлигын эсрэг үйл ажиллагааны дэд зэс нээлгэн Дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, Шуур ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийн захирамж, хэрэгжилтийн тайлан, “Шил” ажиллагааны хүрээнд МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тайланг байршуулаад байна. | 100% | |
| 4 | | 1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | | -2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах | | | Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан авлигын мэдээлэл хүлээн авах 2 төрлийг постерийг бэлтгэн дүүргийн веб сайтад байршуулж, Авлигын эсрэг хуулийг сурталчлах 2 төрлийн гарын авлага бэлтгэн 30 гаруй иргэдэд хүргэн ажиллав.<br>Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг шүгэл үлээхэд уриалах, соён гэгээрүүлэх зорилгоор сурталчилгааны материал байршуулах боломжтой 3 самбарын судалгааг гарган Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс хүргэн ажиллав. Судалгаагаар УБ-Замын үүд чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын дагуу 45м2, 8.7м2 хэмжээтэй 2 самбар, 2 дугаар хорооны байрны хойд хэсэгт 12м2 хэмжээтэй 1 самбар байна.<br>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай хамтран УБ-Замын үүд чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын дагуу 45м2 самбарт Авлигыг мэдээлэх пост байршуулахаар төлөвлөгдсөн. | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх. | | | | |
| 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | | | | | | | | |
| 5 | | 2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх; | | -Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг” сургалтад Төрийн албанд шинээр томилогдсон 5 албан хаагч, “Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах тухай” цахим сургалтад шинээр томилогдсон эрх бүхий 2 албан тушаалтан, “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”, “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө” түүний хэрэгжилт, үд дүнг хэлэлцэх сургалтад 1 албан хаагчийг хамрууллаа.<br>Дүүргийн хэмжээнд ЭБАТ хариуцан ажилладаг эрх бүхий албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллийг тухай бүр өгөн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд бүртгэлийн системд ЭБАТ-ын эрх нь цуцлагдсан байсан 1 эрх бүхий албан тушаалтын эрхийг сэргээн өгч, шинээр ЭБАТ-ын эрх авсан 2 албан тушаалтан /Дотоод аудит, Боловсролын хэлтэс/-нд мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллийг тухай бүр өгч ажиллав.<br>Мөн шинээр ХАСУМ болон ХАСХОМ бөглөж байгаа 7 албан тушаалтанд холбогдох арга зүйн зөвлөгөөг өгөн ажилласан болно. | 100% |
| 6 | | 2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд | | -Өөрсдийн нөөц | - | - | Архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо хороо тус | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | | бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | | бүрээр гарган УБЗАА-нд судалгааг хүргэв. Судалгаагаар архи согтууруулах ундаа худалддаг, түгээдэг 16 цэг байна. Шинэчлэгдсэн судалгаа, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг bagakhangai.ub.gov.mn цахим хуудас, төрийн үйлчилгээний цонхонд байршуулан, зөвшөөрөл шинээр авах 6, зөвшөөрөл дууссан 13 худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд мэдээлэл зөвлөгөөг өгч ажиллаа.<br>УБЗАА-наас "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн цахим болон танхимын сургалтыг 2 удаа зохион байгуулан худалдаа үйлчилгээ эрхлэгч 16 иргэнийг хамруулан "Гэрчилгээ" олгов.<br>Дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран худалдаа, үйлчилгээний 13 иргэн, аж ахуйн нэгж, газруудад зөвлөн туслах, хяналт шалгалтыг 1 удаа зохион байгуулан Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэг, Хүний хувийн мэдээллийг хамгаалахад үйлчилгээний байгууллагаас анхаарах зүйл 2 төрлийн плакат 52ш тарааж авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээллийг өгч ажиллав. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал гараагүй болно. | 70% |
| 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | | | | | | | | |
| 7 | | 3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх; | | -Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; - Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан | - | - | Төрийн байгууллага хувийн хэвшлийн хооронд байгуулсан гэрээнд авлигаас ангид байх авлигыг мэдээлэх гэсэн 2 заалтыг тусгуулан ажиллаж байна. Үүнд:<br>Гэрээний нэмэлт нөхцөлд:<br>1.Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй<br>2.Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | | нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.<br>гэсэн 2 заалтыг тусгуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 11 иргэний гэрээнд тусгасан байна. | |
| 8 | | 3.2. "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | | -Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх. | | | Тус дүүрэгт олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтад нийцэх Иргэний нийгмийн байгууллага болон Төрийн бус байгууллага байхгүй байна.<br>Тус заалтыг хэрэгжүүлэх боломж нөхцөлийн талаар дүүргийн удирдах албан тушаалтнуудад 3 удаа танилцуулан ажилласан болно. Удирдах албан тушаалтнуудын зүгээс дүүрэгт энэ онд 2 төрийн бус байгууллага байгуулагдах тул тус ТББ-аар олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн гэсэн чиглэлийг өгсөн болно.<br>Тайлангийн хугацаанд тус ТББ-д байгуулагдаагүй болно. | 30% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | | | | | |
| 9 | | 4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | | -Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх ; | | | Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт: "Иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хурдан шуурхай, хүндрэл чирэгдэлгүй, хамгийн ойр цэгээс хүргэх" гэж заасны дагуу хороодын цогцолбор байранд төрийн цахим үйлчилгээний "Хурдан" цэгийг байгуулан, 12,0 сая төгрөгийн өртөг бүхий техник тоног төхөөрөмжөөр тохижуулав. 2-р хорооны "Хурдан" цэг нь 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд нийт 24 төрлийн лавлагаа, мэдээллийг 325 иргэнд үзүүллээ.<br>2023 онд 17 байгууллагад иргэдээс нийт 290 өргөдөл ирснээс 280 өргөдлийг хуулийн хугацаанд, 6 өргөдлийг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн ба 4 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.<br>2023 оны 3-р улиралд 99 зөрчил гарч, зөрчлийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 45% буурсан үзүүлэлттэй байна. Иргэдээс нутгийн захиргааны байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлыг дийлэнх хувийг Ажилд орох хүсэлт эзэлж байгаа бөгөөд авлига албан тушаалтай холбоотой өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байна.<br>Шийдвэрлэлтийн дүн мэдээг улирал бүр дүүргийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж тайланг холбогдох дээд шатны байгууллагад хүргэн ажиллаж байна.<br>Өргөдөл, гомдлын талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор 1, 2 дугаар хороо болон Засаг даргын Тамгын газрын байранд "Өргөдөл, гомдлын мэдээлэл" самбар байршуулан, өргөдөл, гомдол хүлээн авах албан хаагчийн мэдээлэл, өргөдөл хүлээн авах эх үүсвэр, өргөдөл гаргахад шаардагдах мэдээллийн жагсаалт, удирдлагуудын иргэдтэй хийх уулзалтын хуваарийг тус тус байршуулав. Мөн дүүргийн веб сайт болох | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | www.bagakhangai.ub.gov.mn сайтад тайлан мэдээг тухай бүр байршуулж байна. | |
| 10 | | 4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх; | | -2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; Тайланд нотломжийг хавсаргасан байх | | | Тус ажлын хүрээнд удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтын журам, хуваарийг дүүргийн Засаг даргын 2023 оны А/44 дүгээр захирамжаар шинэчлэн батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллав. Энэ онд УИХ-ын гишүүн болон дүүргийн Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг 3 удаа зохион байгуулж, 40 аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор 550 гаруй албан хаагчидтай уулзаж, санал хүсэлтийг сонсов. Уулзалтаар 82 иргэнээс 142 санал хүсэлт гаргаж, холбогдох тайлбар, мэдээллийг уулзалтын үеэр өгч ажиллалаа.<br>Уулзалтаар Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл гаргаагүй болно. | 70% |
| 11 | | 4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | | -Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх | | | Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх иргэдийн санал асуулгыг авах QR болон үйлчилгээний тоон мэдээллийг ирүүлэх тухай албан бичгийг 12 байгууллагад хүргүүлэн, үйлчилгээний тоон нэгтгэлийг НЗДТГ-т 7 хоног бүрийн Пүрэв гарагт хүргүүлэн ажиллаж байна. 2023.05.15-2023.06.08-ны өдрийн хугацаанд 12 байгууллага давхардсан тоогоор 50 нэр төрлийн үйлчилгээг 1937 иргэнд үзүүлсэн байна. Үүнээс 20 иргэн QR уншуулан, санал асуулгыг бөглөсөн байна. Мөн Нийслэлийн статистикийн газраас дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгжийн чиг үүрэг, ажлын ачааллыг жигдрүүлэх, нэгж хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгааг 2023 оны 06 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд хийж, судалгааг цаасаар суурьтайгаар НЗДТГ-т хүргүүлэн ажиллалаа. Судалгаанд нийт 14 байгууллагын 151 албан хаагч | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамрагдав. Судалгаагаар төрийн албаны хүнд суртал, хүндрэл бэрхшээлтэй холбоотой гомдол мэдээлэл гараагүй болно.<br>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 5 "Ш" ажиллагааны хүрээнд дүүрэгт зохион байгуулагдаж байгаа "Шуур", "Шил", "Шугэл" ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар сэтгэл ханамжийн судалгааг бэлтгэн иргэдээс авсан болно. Судалгаагаар: "Шуур" ажиллагааны хэрэгжилт, үр дүн сайн гэж 50%, "Шил" ажиллагааны хэрэгжилт, үр дүн сайн гэж 40.9%, "Шугэл" ажиллагааны хэрэгжилт, үр дүн сайн гэж 59% нь үнэлсэн байна.<br>Мөн Та https://bagakhangai.ub.gov.mn/ сайтын Авлига цонхонд байршуулсан "Таван Ш" ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан мэдээлэлтэй танилцаж байсан уу гэсэн асуултад Тийм гэж 27.2%, Үгүй гэж 72.8% хариулсан байна.<br>Авлигатай тэмцэх газрын захиалгаар "Шударга байдлын үнэлгээ -2023" судалгааны ажлыг "Эс Ай Си Эй" ХХК-тай хамтран 3 бүлгийн хүрээнд зохион байгууллаа.<br>Багц-1: Иргэд үйлчлүүлэгчээс авах судалгаа -150 иргэн<br>Багц-2:Төрийн албан хаагчаас авах судалгаа -15 албан хаагч<br>Багц-3: Бодлогод оролцогч шинжээчдийн судалгаа -20 шинжээч нийт 185 иргэд албан хаагчдыг хамруулсан байна. Судалгааг түүврийн аргаар сонгож судлаач өөрөө асууж бөглөх зарчмаар авсан болно. | |
| 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | | | | | | | | |
| 12 | | 5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р | | -<br>Танилцуулах арга хэмжээг зохион | | | Дүүргийн 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан Засаг даргын Тамгын газрын Удирдах бүрэлдэхүүнээс санал авч нэгтгэн Дүүргийн Засаг даргын 2023 оны А/59 дүгээр | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах; | | байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Арга хэмжээнд удирдлагын -Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | | захирамжаар хэрэгжүүлэх 13 арга хэмжээтэйгээр батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 95.3%-тай байна.<br>Тус ажлын хүрээнд:<br>1. “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүн тооцож, тайлагнах<br>2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, саналыг хүлээн авах, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах гэсэн 2 саналыг хүлээн авч үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.<br>Нийслэлийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар дүүргийн удирдлагуудад 3, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн албан хаагчдын хуралд 1 удаа танилцуулан удаашралтай болон хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахад хүндрэлтэй заалтыг танилцуулав.<br>Тухайлбал 3.2 дэх хэсэгт заасан Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх гэсэн заалтын хүрээнд дүүрэгт энэ онд багтаан дүүргийн “Монголын залуучуудын холбоо”, “Эмэгтэйчүүдийн холбоо”-г байгуулах, тус ТББ-аар олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх гэсэн чиглэл өгсөн болно. Одоогоор тус ТББ-д байгуулагдаагүй байна. | |
| 13 | | 5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал; | | -Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх. | | | Тусгасан санал байхгүй байна. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | | 5.3. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах. | | -Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -khutulbur.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх, -Тайлагнасан байх. | | | 2023-2024 оныг Монгол Улсын засгийн газраас Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Дүүргийн Засаг даргын 2023 оны А/01 дүгээр захирамжаар дүүргийн хэмжээнд 2023 оныг “Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. 3 дугаар улирлын байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 86.6% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн ” гэж үнэлгдээд байна. Зорилтот жилийн биелэлтийг дүүргийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар 3 дугаар улирлын хэрэгжилт, анхаарах асуудлыг хэлэлцүүллээ. | 100% |
| БИЕЛЭЛТ | | | | | | | | 85.3% |

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОТГОНЖАРГАЛ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,ҮНЭЛГЭЭ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЦЭНГЭЛ